

Яамны болон шинжлэх ухааны эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Баяржаргал Энхцэцэг

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.1. Зорилт 1. Шинжлэх ухааны салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх							
1	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл, Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлнэ.	Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөл.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/48, А/177, дугаар тушаалаар тус тус ажлын хэсгийг байгуулсан.	Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг тус тус боловсруулсан байна.	Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд саналаа өгч, хуулийн төслийн үзэл баримтлалыг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батласан. Монгол Улсын Засгийн газраас 2024.04.18-ны өдөр Шинжлэх ухаан, технологийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан. УИХ-ын даргын 2024.04.19-ний өдрийн "Ажлын дэд хэсэг байгуулах тухай"	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					<p>60 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын дэд хэсэгт ажилласан бай тус ажлын хэсэг 2024.04.30-ны өдөр хуулийн төслийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын байнгын хороогоор хэлэлцүүлсэн. Шинжлэх ухаан, технологийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг 2024.05.03-ны өдөр УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлэгдсэн батлагдсан. Мөн хуулийг 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр УИХ-ын дарга Г.Занданшатар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан болон шинжлэх ухааны салбарын эрдэмтэн мэргэдэд хүлээлгэн өгсөн.</p> <p>Хавсралт: 2 файл</p>		
2	Шинжлэх ухааны салбарын хэмжээнд 2024 онд батлагдсан захиргааны хэм	Захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлэхээр хүсэлт ирүүлсэн тохиолдолд	Шинжлэх ухааны салбарт мөрдүүлэхээр захиргааны хэм хэмжээний актыг	Захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд тухай бүрд нь бүртгүүлж, албан	2024 оны эхний хагас жилд шинжлэх ухааны салбарт улсын нэгдсэн бүртгүүлэхээр ирүүлсэн захиргааны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	хэмжээний актыг тухай бүрд нь улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, албан хаагчдад мэдээлнэ.	тухай бүрд нь бүртгүүлэн, дотоод сүлжээгээр ажилтан, албан хаагчдад мэдээлэл хүргэх.	ирүүлсэн тохиолдолд улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байх.	хаагчдад мэдэгдсэн байна.	хэм хэмжээний актын төсөл байхгүй байна.	сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 30% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
3	Шинжлэх ухааны салбарт шинээр боловсруулах захиргааны хэм хэмжээний актын төсөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.	Холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан байх.	Шинжлэх ухааны салбарт өнгөрсөн онд нийт 5 захиргааны хэм хэмжээний актыг хянаж хууль, эрх зүйн зөвлөгөө үзүүлсэн байна.	Шинжлэх ухааны салбарт шинээр боловсруулах захиргааны хэм хэмжээний актын төсөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу хянау хууль эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг өгч ажилласан байна	2024 оны эхний хагас жилд шинжлэх ухааны салбарт дараах эрх зүйн актын төслийг хянаж эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэн ажилласан. Үүнд: 1.Шинжлэх ухаан технологийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн үзэл баримтлалын төсөл, 2.Шинжлэх ухаан технологийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл, 3.Орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төслийн нээлттэй шалгаруулалт зохион байгуулах, инновацийн грант олгох үлгэрчилсэн журмын төсөл болон Засгийн газрын тогтоолын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					<p>төсөл. 4.Шинжлэх ухааны салбарт Хүнсний эрдэм, шинжилгээ, судалгааны хүрээлэнгийн дүрмийн төсөл, Засгийн газрын тогтоолын төслийг тус тус хянасан. Тус хүрээлэн Засгийн газрын 2024.05.15-ны өдрийн 206 дугаар тогтоолоор байгуулагдсан.</p> <p>5.Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төслийг холбогдох материалын хамт хянаж эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн. Тус тогтоолын төслийг Засгийн газрын 2024.05.15-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор батлагдаж Шинжлэх ухааны академийн Их сургууль байгуулагдсан.</p>		
1.2. Зорилт 2. Хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх							
4	Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Засгийн	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	Засгийн газрын хуралдаанаар нийт 42 асуудал	Засгийн газрын хуралдааны төлөвлөгөөний	2023.12.27-ны өдрийн 1а/6296 тоот албан бичгээр Боловсрол,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

	газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын саналын төлөвлөөг гаргаж, хэрэгжилтийн явцад хяналт тавина.	асуудлын төлөвлөгөөний биелэлт ахиц, өөрчлөлтийн явцын тайлагналтын байдал.	хэлэлцүүлсэн.	дагуу биелэлтийг хангаж ажиллах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж ажилласан байна.	шинжлэх ухааны салбарт 2024 оны 01 дүгээр улиралд, 2024.03.29-ний өдрийн 1а/1257 тоот албан бичгээр Боловсрол, шинжлэх ухааны салбарт 2024 оны 02 дугаар улиралд, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх, танилцуулах асуудлын төлөвлөгөөг сайдаар батлуулан журамд заасан хугацаанд Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. 2024 оны эхний хагас жилд төлөвлөгөөнд тусгагдсан 16, төлөвлөгөөнд тусгагдаагүй 8 Нийт 24 асуудал Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэгдсэн батлагдсан байна. Батлагдсан 24 асуудлын 2 асуудал танилцуулагдсан, 22 асуудал хэлэлцүүлэгдсэн. Хавсралт: 2 файл	сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
5	Худалдан авах ажиллагааны үйл ажиллагаанд	Яамны дотоод болон яамнаас хэрэгжүүлж буй худалдан авах	Худалдан авах ажиллагаатай холбоотой	Яамны дотоод болон яамнаас хэрэгжүүлж буй	2024 оны эхний хагас жилд худалдан авах ажиллагааны үйл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р	Өөрийн үнэлгээ: 100%

	хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажиллана.	ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байх.	тушаал шийдвэр, гэрээний төслийг хянаж, үнэлгээний хорооны гишүүнээр тус тус ажилласан байна.	худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	ажиллагаанд дараах байдлаар оролцсон. Үүнд: 1. БШУЯ-ны дотоод болон тус яаман дээр хэрэгжиж буй 5 төсөл, харьяа байгууллагуудын /БЕГ, БМТТ/ Нийт 28 үнэлгээний хороонд гишүүнээр орж ажилласан. 2. Нийт 28 үнэлгээний хорооны 84 удаагийн танхимын болон цахим хуралд тус тус оролцож санал, зөвлөгөөг үзүүлсэн. 3. Үнэлгээний хороотой 28, захилагчийн эрхтэй холбоотой 112, Нийт 140 албан бичгийг хянасан. 4. Худалдан авах үйл ажиллагаатай холбогдох гэрээ, гэрээний нэмэлт өөрчлөлт зэрэг 53 гэрээний төслийг тухай бүрд хууль, эрх зүйн хүрээнд хянаж ажилласан байна.	сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 100%  Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
6	Иргэд, төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу	Иргэд, төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг, хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэнэ.	Иргэд, төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг ирснийг хууль тогтоомж, дүрэм журмын	Иргэд, төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хугацаанд нь	2024 оны эхний хагас жилийн байдлаар иргэд, төрийн байгууллага болон бусад аж ахуй нэгж байгууллагаас нийт 15 хариутай албан бичиг, 5 хариугүй албан бичиг, 2 өргөдөл ирсэн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100%  Нэгжийн даргын үнэлгээ: 90%  Нэгжийн даргын

	хугацаанд нь хариу хүргүүлнэ.		хүрээнд хянан шийдвэрлэсэн байна.	хүргүүлж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.	байна. Хариутай 15 албан бичиг болон 2 өргөдлийг тус тус холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судлан хугацаанд хуульд заасан хугацаанд нь хариуг хүргүүлэн ажилласан.	сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
7	Хууль санаачлагчаас боловсруулж ирүүлсэн хууль тогтоомж болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийн төслийг судлан үзэж тус салбарын бодлого, чиглэлтэй нийцүүлэх санал боловсруулж хүргүүлнэ.	Холбогдох хууль тогтоомж, салбарын бодлого, чиглэлд нийцсэн байх.	Хууль санаачлагчаас боловсруулж ирүүлсэн хууль тогтоомж болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийн төслийг судлан үзэж хариуг хүргүүлсэн.	Хууль тогтоомж болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийн төслийг судлан үзэж тус салбарын бодлого, чиглэлтэй нийцүүлэх санал боловсруулж хүргүүлсэн байна.	2024 оны эхний хагас жилийн байдлаар Хууль санаачлагчаас боловсруулж санал авахаар нийт 32 саналын бичиг ирснийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд судлан, хугацаанд хариуг хүргүүлэн ажилласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
<b>1.3. Зорилт 3. Хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх</b>							
8	Сайд, төрийн нарийн бичгийн даргын батлах захиргааны шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ.	Сайд, Төрийн нарийн бичгийн даргын батлах захиргааны шийдвэрийн эрх зүйн үндэслэл хангагдсан байна.	2023 онд Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийг хууль тогтоомжид нийцүүлэн зөрчилгүй хянасан байна.	Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн үндэслэлийг шинээр батлагдсан албан хэрэг хөтлөлтийн чанарт нийцүүлж хяналтын чанарыг дээшлүүлсэн байна.	2024 оны эхний хагас жилд Нийт 264 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянасан байна. Үүнээс: 1.Сайдын А тушаал-73, 2.Сайдын Б тушаал-11, 3.Төрийн нарийн бичгийн даргын А тушаал-121, 4.Төрийн нарийн бичгийн даргын Б тушаал-59 байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн

					Тушаалын төслүүдийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хянаж, албан хэрэг хөтлөлтийн чанарт нийцүүлж хяналтын чанарыг нийцүүлэн ажилласан.	сар	хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
9	Шинжлэх ухааны салбар болон яамны дотоод үйл ажиллагаатай холбогдох гэрээний төслийг хууль тогтоомжид нийцүүлэн, хянах эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ.	Боловсрол, шинжлэх ухааны яамнаас бусад байгууллагатай байгуулах гэрээний болон яамнаас гарах шийдвэрийн төслийн эрх зүйн үндэслэлийг хянах, сайд болон аппаратад шийдвэр боловсруулан гаргахад эрх зүйн дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид нийцсэн байх.	Шинжлэх ухааны салбар болон яамны дотоод үйл ажиллагаатай холбогдох гэрээний төслийг алдаа, зөрчилгүй хянаж, хууль, эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн байна.	Гэрээний төслийн эрх зүйн үндэслэлийг хянан сайд болон аппаратад шийдвэр боловсруулан гаргахад эрх зүйн дэмжлэг үзүүлсэн байна.	2024 оны эхний хагас жилд Шинжлэх ухааны салбартай холбоотой 57, яамны дотоод үйл ажиллагаатай холбоотой 46 Нийт 103 гэрээний төслийг холбогдох хууль, тогтоомжийн хянаж, хууль, эрх зүйн зөвлөгөө үзүүлэн ажилласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
10	Шинжлэх ухааны салбар болон яамны дотоод үйл ажиллагаанд хамаарах асуудлаар яаманд холбогдуулан нэхэмжлэгч, хариуцагчаар татагдсан шүүхийн маргаантай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд	Шүүхийн процессийн шатанд оролцсон байдал.	Шүүх дээр хянан хэлэлцэгдсэн хэрэгт төлөөлөл хэрэгжүүлэн оролцсон байна.	Яамны итгэмжлэлээр оролцох оролцоог бүрэн хангаж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хангаж ажилласан байна.	2024 оны эхний хагас жилийн байдлаар дараах шүүхийн хэрэг, маргаанд яамыг төлөөлөн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан. Үүнд: 1. БШУЯ-д холбогдуулан Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан "Манхан Уст" ХХК-ийн Ажил гүйцэтгэх	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн



<p>яамыг төлөөлж итгэмжлэлээр оролцоно.</p>			<p>гэрээний барьцаа хөрөнгө болох 294,412,200 төгрөгийг суллах тухай нэхэмжлэлтэй иргэний хэргийг тус шүүхийн шүүгч Д.Батхуягийн 2024.02.27-ны өдрийн 181/ШШ2024/00762 тоот захирамжаар хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.</p> <p>2. БШУЯ-д холбогдуулан Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан "Хашхан" ХХК-ийн Захиргааны актыг хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгох тухай нэхэмжлэлтэй захиргааны хэргийг тус шүүхийн шүүгч Д.Эрдэнэчимэгийн 2024.01.22-ны өдрийн 128/ШШ2024/0075 тоот захирамжаар хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.</p> <p>3.БШУЯ-д холбогдуулан Сүхбаатар дүүрийн Иргэний хэргийн шүүхэд "Киндер парадайс" ХХК-ийн Ажил гүйцэтгэх гэрээний үлдэгдэл</p>	<p>байдал: 100%</p>
---	--	--	---	---------------------

					<p>төлбөр болох 3 тэрбум төгрөгийг хариуцагчаас гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэгт хариуцсан чиг үүргийн хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажиллаж байна. Тус шүүхийн 2024.04.24-ний өдрийн хурлаар маргаанд Сангийн яамыг гуравдагч этгээдээр оролцуулах Шүүгчийн захирамж гарсан. Сангийн яамны хариу тайлбар шүүхэд хүргэгдэх, шүүхээс дараагийн хурлыг товыг хүлээх явцын шатанд байна.</p> <p>Хавсралт: 4 файл</p>		
11	<p>Яамны дотоод үйл ажиллагаа, зохион байгуулахтай холбогдох эрх зүйн зохицуулалт, дүрэм, журмын төсөлд санал боловсруулах, батлуулахад дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Яамны дотоод ажилтай холбоотой дүрэм, журам хууль тогтоомжийн хүрээнд боловсруулагдсан эсэхэд хяналт хийж, дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Яамны дотоод үйл ажиллагаа, зохион байгуулахтай холбогдох эрх зүйн актыг хууль тогтоомжид нийцүүлэн хянаж хууль, эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн байна.</p>	<p>Яамны дотоод үйл ажиллагаатай холбоотой хууль дүрэм, журмын төсөлд санал өгч, боловсруулалтад дэмжлэг үзүүлж тухайн төслийг батлуулахад холбогдох нэгжийн албан хаагчидтай хамтран ажилласан байна</p>	<p>2024 оны эхний хагас жилийн байдлаар яамны дотоод үйл ажиллагаа, зохион байгуулахтай холбогдох дараах эрх зүйн актыг хууль тогтоомжид нийцүүлэн хянаж хууль, эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн байна. Үүнд: 1. Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт оруулах тухай журмын</p>	<p>1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	<p>Өөрийн үнэлгээ: 100%</p> <p>Нэгжийн даргын үнэлгээ: 90%</p> <p>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн</p>

					төсөл, 2. Албан хаагчдын нийгмийн баталгааны стратегийн төлөвлөгөө, 3. Яамны эцэг эхийн зөвлөлийн ажиллах журмын төсөл, 4. Яамны хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээний төслийг сайжруулан боловсруулж нэгдсэн нэг драптыг албан хаагчдад түгээж өдөр тутмын үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна.		байдал: 50%
--	--	--	--	--	--	--	-------------

1.4. Байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хийж гүйцэтгэх.

12	Удирдлагаас өгсөн албан тушаалын чиг үүрншт хамаарах ажил, үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийж гүйцэтгэх.	Удирдлагаас өгсөн ажил үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.	Удирдлагаас өгсөн ажил үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн байна.	Удирдлагаас өгсөн ажил үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн байна.	2024 оны эхний хагас жилд Удирдлагаас өгсөн дараах ажил үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн байна. Үгийн тоо 2000-аас хэтэрсэн тул хавсралт файлаар оруулав. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
13	Байгууллагын үйл ажиллагаанаас	Албан хаагчийн ажлын үр дүн, үр	Оролцсон	Байгууллагын үйл ажиллагааны	2024 оны эхний хагас жилийн байгууллагын	1-р сар, 2-р сар, 3-р	Өөрийн

<p>гадуурх цаг үеийн, олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцох.</p>	<p>нөлөө дээшлэх, байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдэнэ.</p>	<p>байдал.</p>	<p>чиглэлийн хүрээнд төлөвлөгөөнөөс гадуурх цаг үеийн, олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцсон байна.</p>	<p>үйл ажиллагаанаас гадуурх зохион байгуулагдсан дараах арга хэмжээ хамрагдсан байна. 1. 2024.06.15-16 ны өдрүүдэд Монгол-Японы эмнэлэг дээр эрх илрүүлэгийн үзлэгт хамрагдсан. 2. 2024.03.17-ны өдөр зохион байгуулагдсан Боловсрол, шинжлэх ухааны яам түүний харьяа байгууллагуудын дунд зохион байгуулагдсан Спортын арга хэмжээний Сагсан бөмбөгийн төрөлд багийн хамт олны хамт оролцсон. 3.2024.02.26-ны өдөр Хууль, зүй дотоод хэргийн яаман дээр зохион байгуулагдсан Компанийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэгт хамрагдсан.</p>	<p>сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	<p>үнэлгээ: 100%  Нэгжийн даргын үнэлгээ: 100%  Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%</p>
--	---	----------------	--	--	--	--

**НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ**

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Шинээр батлагдсан хууль тогтоомж, эрх зүйн актыг тухай бүр судлах.	Шинээр батлагдсан хууль тогтоомжийг судлана.	Шинээр батлагдсан хууль тогтоомж, эрх зүйн актыг тухай бүр судлаж, холбогдох мэдээлэлтэй болсон байна.	Салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх	Шинээр батлагдсан хууль тогтоомж, эрх зүйн актыг тухай бүр судлаж, холбогдох мэдээлэлтэй болж, өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг тухай бүр судлан ажиллаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100%  Нэгжийн даргын үнэлгээ: 0%
2	Өөрийн ажил, мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх.	Холбогдох сургалтад хамрагдах.	Сургалтад хамрагдсан байдал.	Өөрийн ажил, мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байна.	2024 оны эхний хагас жилийн байдлаар өөрийн ажил, мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхээр дараах арга хэмжээнд хамрагдсан. Үүнд: 1.Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулж буй "Менторшип-2024" хөтөлбөрт хамрагдахаар сонгогдсон бөгөөд энэхүү хөтөлбөр нь 04-10 дугаар сарын хооронд хэрэгжинэ. Ментороор Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч Т.Бадрах байна. 2.2024.02.23-ны өдөр тус яаман дээр зохион байгуулагдсан Худалдан авах ажиллагааны мэргэшсэн албан хаагч бэлтгэх бүтэн өдрийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100%  Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					<p>сургалтад хамрагдсан. 3.2024.01.04-ны өдөр Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх шалгалтад тэнцэн Хуульчийн тангараг өргөн, тус өдрийн 7363 тоот гэрчилгээг гардаг авсан. 4.2024.05.07-08-ны өдрүүдэд Монголын Хуульчдын холбоон дээр зохион байгуулагдсан Шинэ хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдсан. 5. Яамны мэдээллийн цагуудад тогтмол хамрагдсан.</p> <p>Хавсралт: 4 файл</p>	
--	--	--	--	--	---	--

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Яамны болон шинжлэх ухааны эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Баяржаргал Энхцэцэг /...../

Огноо: .....